

ХИЧЭЭЛ 4

УНШИХ ЗҮЙЛС: УЙЛС 12:1-19; ДАГАЛДАГЧДЫН УЙЛС, Х. 143-154.

Шоронд Орсон ба Тарсан нь

Та нарын таньдаг хүмүүст зовлон тохиолдож байсан уу? Та нар тэдэнд яаж тусалсан бэ? Петрийн найзууд нь түүний төлөө залбирсаар, залбирсаар л байсан юм. Гэнэт гайхамшигтай зүйл болов.

X

орон санаат хаан Херод бас нэгэн муухай төлөвлөгөө сэдэн гарaa үрэв. Тэрээр Есүст итгэгчдийн эсрэг муу зүйл сэдсэн байжээ. Дараа нь Петр гэдэг сургаал

номлогчийн эсрэг юм хийх болно. "Харуул. Харуул" гэж тэрээр хашгирлаа.

Цээжлэх Ишлэл:

"Чуулган Бурханд хандаж түүний төлөө залбирч байв"

УЙЛС 12:5.

Тол Санаа:


Бурханы гэр бүлийн гишүүд бие биенийхээ төлөө залбирдаг.



Петр өөрийг нь баривчлахаар ирсэн цэргүүдтэй хамт дуулгавартай явав. Цэргүүд Петрийн шоронд аваачаад гарч нь гинж зүүн хоёр талд нь манах боллоо.

Хүнд гинж нь Петрийн гарыг их холгожээ. Гэсэн ч Петр гомдоллосонгүй. Тэрээр доошоо хүйтэн шалан дээр хана налан суулаа. Тэгээд нүдээ аниад унтах гэж оролдов.

Петр баригдсан тухай мэдээ хотоор тун хурдан тархсан байна. Христэд итгэгч олон хүн Марк гэгдэх Иоханы ээжийн гэрт цугларав. Тэд хамтдаа залбирахаар тэнд олонтаа



цуглардаг байсан юм. Тиймээс энэ бол Петрийн төлөө хамтдаа залбирахад яг тохирсон газар мөн. Ингээд тэд залбираа, залбираа л байв. Тэд шөнө дөл болтол Бурхантай ярьжээ.

Гэнэт шорон дотор Петрийн хоригдож байгаа торон дотор хурц гэрэл гарав. Нэгэн тэнгэр элч Петрийн мөрөн дээр зөвлөн тогшлоо. "Алив, хурдан сэрээрэй" гэж тэнгэр элч хэлэхэд Петрийн гар дахь гинж сулран унажээ. "Углаашаа өмс. Тэгээд хүрмээ өмсөөд намайг дагаад яв." Петр хэлсэн бүхнийг нь хийлээ. Гэхдээ бүх зүйл зүйл шиг санагдаж байсан юм.

Петр, тэнгэр элч хоёр хэсэг цэргүүдийн дундуур чимээгүйхэн явсаар гадагш гардаг төмөр хаалганд хурлээ. Гэтэл хаалга өөрөө онгойчхов. Петр, тэнгэр элч хоёр хамтдаа широнгоос гадагш гарсан байна. Харин дараа нь тэнгэр элч алга болжээ.


Петр нүдээ аниад дахин нээв. Тэр үнэхээр гудамжинд зогсож байсан юм. "Энэ чинь бодит юм байна" гэж тэр чимээгүйхэн шивнэлээ.

Петр Иоханы ээжийнх рүү яаран алхав. Хаалган дээр нь ирээд тогшлоо. Энэ айлын зарц охин Роде үүдэн дээрээ хүрч иржээ. Охин Петрийн хоолойг сонсоод эргэж гүйгээд явчихав. "Петр гадаа, үүдэн дээр ирчихсэн байна" хэмээн тэрээр хашгирлаа.

Петрийн найзууд Роде руу хараад, "Галзуу юм ярих юм." "Энэ ямар ч боломжгүй" гэж тэд хэллээ.

"Үгүй дээ, нээрээ" гэж Роде хариулав.

Петр дахин хаалга тогшжээ.
Хүмүүс арайхийн хаалгаа тайлж өгөхдөө мэл гайхаж хоцров. Хэн нэг нь Петрийн гараас шүүрч дотогш оруулжээ.
Петр Их Эзэн хэрхэн түүнийг тэнгэр элчээ илгээн широнгоос чөлөөлсөн тухай ярихад тэд чих тавин сонсож байлаа. Итгэгчид баяр хөөрөөр бялхан инээж, зарим нь уйлж байсан юм. Дараа нь тэд дахин Бурхантай ярив. Өөрсдийнх нь гүйлтиг сонсож хариу өгсөнд нь тэд Бурханд талархан, магтан алдаршуулжээ.



Дасгал Ажил



ШАББАТ

Энэ долоо хоногт өдөр бүр хичээл дээр үзсэн түүхийг уншаад цээжлэх ишлэлээ давтаарай.

- Чуулган** Сүмийн оройг дуурайлган дүрслэх.
- Бурханд** Дээшээ заах.
- хандаж түүний төлөө**. Бусад руу заах.
- залбирч байв.** Залбирч байгаа мэт гарваа атгах.
- Үйлс 12:5** Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

НЯМ

Шаббат хичээл дээр хийсэн залбирч буй гарваа хэн нэгэнтэй хуваалцахад нь хүүхдээ урамшуулаарай. Мөн түүний төлөө өдөр бүр залбираарай. (Эсвэл хүүхдийнхээ гарыг нэг цаасан дээр зэрэгцүүлж тавьж байгаад хүрээлэн зураад, хайчилж өгөөрэй. Мөн дээр нь "Би чиний төлөө залбирдаг" гэж бичээд дундуур нь нугалаарай.)

ДАВАА

Хүүхдээсээ асуу: Чи өнөөдөр хэний эсвэл юуны төлөө залбирсан бэ? Чи өнөөдөр хэдэн удаа залбирсан бэ? Хуруугаар нь тоолуулаарай.

Цаасан дээр гарваа тойруулан зурахад нь хүүхдэдээ туслаарай. Дараа нь түүнийг нь хайчлаад бүхний нүдэнд ил харагдах газар өлгөөрэй. Энэ нь тэднийг залбирах ёстойг нь сануулах учиртай.

МЯТМАР

Үйлс 12:1-19-г уншиж, харилцан ярилцаарай. Асуух: Бурхан яагаад Петр лүү элчээ илгээсэн гэж чи бодож байна?

Залбирлын гинж хийж эхлэхэд нь хүүхдэдээ



туслаарай. 5 см урт нарийн цаас хайчлаад түүн дээр нь залбирах хүн болон нөхцөл байдлыг бичээрэй. Энэ долоо хоногийн туршид өдөр бүр нэг цаас гинжиндээ энэ мэтээр нэмээрэй.

ЛХАТВА

Хүүхдээ Петрийн оронд тоглуулна уу. Тэрээр найз нөхөд нь түүний төлөө хамтран гүйж байгаа газрын үүдийг тогшино. Тэрээр нэрээ хэлнэ. Гэхдээ хаалгаа тэр дороо нээх хэрэггүй. Хаалгаа нээж өгөхдөө ингэж асуугаарай. Зарц охин Петрийг дотогш оруулалгүй буцаж гүйхэд нь Петрт юу гэж бодогдсон бол?

ПҮРЭВ

Мягмар гарагт эхэлсэн гинжээ тоолж үзээрэй. Гинжин дээрх нэрнүүдийн төлөө дахин залбираарай. Залбирлынхаа хариултуудыг эрж хайгаарай. Хэн нэг хүний төлөө чин сэтгэлээсээ залбирч байсан тухайгаа хүүхдэдээ ярьж өгөөрэй.

БААСАН

Гэрийнхэнтэйгээ хамт магтаалын цагаар Библийн түүхийг хамтдаа жүжиглээрэй. Хүүхдээ хувцасла. Сандал олс ашиглан ямар нэг газрыг шорон болгож ашиглана уу. Тэнгэр элч гарч ирэхэд гар чийдэн тусгаарай.



Залбирлын тухай дуу дуулаарай. Гүйлтиг тань сонсож хариулдаг Бурханд талархлаа илэрхийлээрэй.